



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлгэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.03.15 № 07/519
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Шуудан ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монгол Шуудан ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах, цар хүрээгээ өргөтгөх замаар гадаад мөнгөн гуйвуулгыг 132.0 хувиар, транзит шууданг 35.2 хувиар, гадаад шуудангийн орох урсгалыг жингийн хувьд 144.0 хувиар тус тус нэмэгдүүлсэн нь үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн байна.

Аудитын гол асуудал

Монгол Шуудан ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 21/17 дугаар тогтоолоор 2022 оны нийт орлогыг 22,929.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 21,929.0 сая төгрөгөөр, 1000.0 сая төгрөгийн ашигтай байхаар эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг баталсан. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 4,438.3 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 20,391.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 19,782.2 сая төгрөгийн зардал гарган, 609.3 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 362 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---------------|---|--------------------------|--------------------------|
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 14,304,012,274.34 | 19,385,981,879.08 |
| 1.1.2 | Дансны авлага | 1,561,147,844.30 | 5,886,568,927.89 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | 7,959,558.98 | 41,101,472.25 |
| 1.1.4 | Бусад авлага | 208,294,306.99 | 332,984,445.92 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | 7,769,001.00 | 157,769,001.00 |
| 1.1.6 | Бараа материал | 2,778,743,420.48 | 3,479,935,861.85 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 3,478,342,480.47 | 3,713,694,026.89 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | - | - |
| 1.1.9 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 22,346,268,886.56 | 32,998,035,614.88 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 8,522,799,977.58 | 8,471,048,949.22 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 1,225,448,481.99 | 2,041,828,165.60 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | - | - |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 500,000.00 | 500,000.00 |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | - | - |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | - | - |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | - | - |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | - | - |
| 1.2.9 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 9,748,748,459.57 | 10,513,377,114.82 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 32,095,017,346.13 | 43,511,412,729.70 |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | |
| 2.1 | Өр төлбөр | | |
| 2.1.1 | Богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 6,062,957,616.02 | 17,778,450,709.99 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 35,000.51 | - |
| 2.1.1.3 | Татварын өр | 238,806,355.76 | 168,138,133.12 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 759,786.83 | - |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | - | - |
| 2.1.1.6 | Хүүгийн өглөг | - | - |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | - | - |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 463,892,631.47 | 339,069,766.99 |
| 2.1.1.9 | Нөөц/өр төлбөр/ | - | - |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 548,527,942.84 | 234,143,968.36 |
| 2.1.1.11 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 7,314,979,333.43 | 18,519,802,578.46 |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | - | - |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | - | - |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | - | - |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | - | - |
| 2.1.2.5 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | - | - |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 7,314,979,333.43 | 18,519,802,578.46 |
| 2.3 | Эздийн өмч | | |
| 2.3.1 | Өмч:-терийн | 6,572,700,000.00 | 6,572,700,000.00 |
| 2.3.2 | хувийн | 3,385,936,300.00 | 3,385,936,300.00 |
| 2.3.3 | хувьцаат | - | - |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | - | - |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | 2,538,512,210.45 | 2,538,512,210.45 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 3,379,919,523.85 | 3,379,919,523.85 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | - | - |

Монгол Шуудан ХК -ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

| | | | |
|---------------|---------------------------------------|--------------------------|--------------------------|
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 4,300,458,597.23 | 4,300,458,597.23 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 4,602,511,381.17 | 4,814,083,519.71 |
| 2.3.10 | Эздийн өмчийн дүн | 24,780,038,012.70 | 24,991,610,151.24 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 32,095,017,346.13 | 43,511,412,729.70 |

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | /төгрөгөөр/ | |
|---------------|--|--------------------------|--------------------------|
| | | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 19,838,796,351.51 | 18,491,088,870.70 |
| 2 | Борлуулалтын өртөг | 19,328,556,601.34 | 18,464,332,021.74 |
| 3 | Нийт ашиг(алдагдал) | 510,239,750.17 | 26,756,848.96 |
| 4 | Түрээсийн орлого | 103,289,121.67 | 115,241,194.05 |
| 5 | Хүүгийн орлого | 406,304,998.11 | 584,082,910.22 |
| 6 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /үндсэн хөрөнгө/ | - | - |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | - | - |
| 8 | Бусад орлого | - | - |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | - | - |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 917,446,523.39 | 1,147,771,767.30 |
| 11 | Санхүүгийн зардал | - | - |
| 12 | Бусад зардал | 215,189,538.24 | 170,052,835.67 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 566,539,914.40 | 1,201,078,732.14 |
| 17 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз | 17,882,888.57 | - |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал) | 471,620,611.29 | 609,335,082.40 |
| 19 | Орлогын татварын зардал | 71,574,456.61 | 158,051,990.96 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | 400,046,154.68 | 451,283,091.44 |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 400,046,154.68 | 451,283,091.44 |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | - | - |
| | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | - | - |
| 24 | Орлогын нийт дүн | 400,046,154.68 | 451,283,091.44 |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмч | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|--|------------------|------------------------|-------------------------------------|---------------------------|-------------------------|--------------------------|
| 2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 9,958,636,300.00 | 2,538,512,210.45 | 3,379,919,523.85 | 3,673,789,311.73 | 4,425,622,560.75 | 23,976,479,906.78 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | 400,046,154.68 | 400,046,154.68 |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | 626,669,285.50 | (55,789,334.26) | 570,879,951.24 |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - | (167,368,000.00) | (167,368,000.00) |
| 2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 9,958,636,300.00 | 2,538,512,210.45 | 3,379,919,523.85 | 4,300,458,597.23 | 4,602,511,381.17 | 24,780,038,012.70 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | 451,283,091.44 | 451,283,091.44 |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - | (40,000,042.00) | (40,000,042.00) |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - | (199,710,910.90) | (199,710,910.90) |
| 2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 9,958,636,300.00 | 2,538,512,210.45 | 3,379,919,523.85 | 4,300,458,597.23 | 4,814,083,519.71 | 24,991,610,151.24 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

| | | /төгрөгөөр/ | |
|---------------|---|---------------------------|---------------------------|
| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 102,131,088,744.62 | 125,901,989,790.76 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 20,116,138,649.08 | 14,849,382,704.84 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | - | - |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 13,686,589.77 | - |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | 415,286.40 | - |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | 3,577,925,614.00 | - |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 78,422,922,605.37 | 111,052,607,085.92 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 105,997,364,812.61 | 121,450,100,365.99 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 7,576,084,212.43 | 7,244,776,405.17 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 2,269,634,977.60 | 2,266,214,006.36 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 2,576,691,055.82 | 2,949,629,551.54 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 1,435,630,830.97 | 1,819,030,861.01 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 2,640,000,864.29 | 3,240,415,086.86 |
| 1.2.6 | Газрын төлбөр | - | - |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 1,418,040,429.93 | 1,334,722,721.46 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 95,730,064.77 | 116,694,757.20 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 87,985,552,376.80 | 102,478,616,976.39 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (3,866,276,067.99) | 4,451,889,424.77 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 347,838,409.42 | 357,082,910.22 |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| 2.1.3 | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | - | - |
| 2.1.4 | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | - | - |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 347,838,409.42 | 357,082,910.22 |
| 2.1.7 | Хүлээн авсан ногдол ашиг | - | - |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 2,552,769,138.00 | 1,777,149,476.43 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 2,388,365,712.00 | 1,343,924,826.43 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 164,403,426.00 | 283,224,650.00 |
| 2.2.3 | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | - | 150,000,000.00 |
| 2.2.4 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| 2.2.5 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | - | - |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (2,204,930,728.58) | (1,420,066,566.21) |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | | |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| 3.1.2 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| 3.1.3 | Төрөл бүрийн хандив | - | - |
| 3.1.4 | Гадаад валютын ханшийн зерүүний олз | - | - |

Монгол Шуудан ХК -ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

| | | | |
|------------|---|---------------------------|--------------------------|
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 161,552,422.37 | 192,939,819.90 |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | - | - |
| 3.2.2 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | - | - |
| 3.2.3 | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | - | - |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | 161,552,422.37 | 192,939,819.90 |
| 3.2.5 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | - | - |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (161,552,422.37) | (192,939,819.90) |
| 4 | Валютын ханшийн зөрүү | (522,204,291.98) | 2,243,086,566.08 |
| 5 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (6,754,963,510.92) | 5,081,969,604.74 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 21,058,975,785.26 | 14,304,012,274.34 |
| 7 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 14,304,012,274.34 | 19,385,981,879.08 |

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2021 оны гүйцэтгэл | 2022 он | | Зөрүү | Хувь |
|----|-------------------------------------|-------------|--------------------|------------|-----------|---------|-------|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Нийт орлого | сая төг | 20,932.8 | 22,929.0 | 20,391.5 | (2.6) | 88.9 |
| 2 | Нийт зардал | сая төг | 20,461.2 | 21,929.0 | 19,782.2 | (3.3) | 90.2 |
| 3 | Татварын өмнөх ашиг | сая төг | 471.6 | 1,000.0 | 609.3 | (390.7) | 60.9 |
| 4 | Орлогын татварын зардал | сая төг | 71.6 | 100.0 | 158.1 | 58.1 | 58.1 |
| 5 | Цэвэр ашиг | сая төг | 400.0 | 900.0 | 451.3 | (448.7) | 50.1 |
| 6 | Нийт ажиллагсад | хүн | 1,004.0 | 1,024.0 | 1,024.0 | - | 100.0 |
| 7 | Цалингийн сан | сая төг | 9,326.9 | 10,010.7 | 9,184.4 | 826.3 | 91.7 |
| 8 | Нийт авлага | сая төг | 1,777.4 | 4,000.0 | 6,260.7 | 2,260.7 | 156.5 |
| 9 | Нийт өр төлбөр | сая төг | 7,309.4 | 10,000.0 | 18,519.8 | 8,519.8 | 185.2 |
| 10 | Нийт хөрөнгө оруулалт | сая төг | 959.1 | 9,326.6 | 2,081.3 | 7,245.3 | 22.3 |
| 11 | Үүнээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр | сая төг | - | - | - | - | - |
| 12 | Ногдол ашиг | сая төг | 200.0 | 270.0 | - | - | 100.0 |
| 13 | Элэгдлийн зардал | сая төг | 1,318.9 | 1,397.0 | 1,011.8 | 385.2 | 72.4 |